



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/366

Булган сум

**Олон наст ургамал тариалах
хашааны зардлын эрх шилжүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хуралдааны XIX/08 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хутаг-Өндөр, Орхон суманд биологийн төрөл зүйлийн ургамлыг нэмэгдүүлэх зорилгоор олон наст ургамал тариалах хашааны зардлын хуваарилалтыг хавсралтаар баталж, хавсралтад тусгагдсан арга хэмжээг хууль, тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж, тайлагнахыг Хутаг-Өндөр сумын Засаг дарга (П.Лхагва-Очир), Орхон сумын Засаг дарга (Н.Амартүвшин) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Дээрх ажилд шаардагдах 13,890,000 (арван гурван сая найман зуун ерэн мянга) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнээс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

4.Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т үүрэг даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 21-ны/ний өдрийн А/366 дугаар
захирамжийн хавсралт

Олон наст ургамал тариалах хашааны зардлын хуваарилалт

№	Сумын нэр	Хашааны зардал	Тоо ширхэг	Нийт зардал (төг)	Эрх шилжүүлсэн сумын Засаг даргын нэр
1	2	3	4	5	6
1	Хутаг-Өндөр сум	4 630 000	2	9 260 000	П.Лхагва-Очир
2	Орхон сум	4 630 000	1	4 630 000	Н.Амартүвшин
Нийт				13 890 000	